



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/244

Баян-Өндөр сум

Гамшгийн аюулын зарлан мэдээллийн
дохиогоор ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 13 дугаар зүйлийн 13.2.5, 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.11 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулийг аймгийн хэмжээнд 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 16:00 цагт, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлын үзлэгийг тус өдрийн 17:00 цагт “Амарын талбай”-д тус тус зохион байгуулсугай.

2. “Гамшгийн аюулын дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний хэмжээнд зохион байгуулах бэлэн байдлын үзлэгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж, түр цугларах талбайд аюулгүй байдлыг ханган шилжих дадлага, сургуульд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд бүрэн хамрагдахыг даалгасугай.

4. Бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ш.Баасандорж, Баян-Өндөр сумын Засаг дарга Б.Мөнхбаяр, Жаргалант сумын Засаг дарга Л.Учрал нарт тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганзоригт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЗОРИГТБАЯР

Аймгийн Засаг даргын 2026 оны
 03 дугаар сарын 11-ны өдрийн 16244 дугаар
 захирамжийн 01 дүгээр хавсралт

**ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН АЮУЛЫГ ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ,
 ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГООР АЖИЛЛАХ ДАДЛАГА, СУРГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ
 АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго: Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ын дагуу дадлага, сургуулийг зохион байгуулах, 2017 оны 67 дугаар тогтоол "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-ийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах, хүртээмжтэй мэдээлэл олгоход оршино.

д/д	Зохион байгуулах ажил, үйлчилгээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Нэг. Сургалт, дадлагын бэлтгэл ажлын талаар				
1.1	Гамшгаас хамгаалах алба, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, байгууллагууд, их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, байгууллагын ойролцоох “Цугларах” талбайг тодотгож, тэмдэгжүүлэх	III/25-ны өдрийг хүртэл	ОБГ	-
1.2	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах техник хэрэгслийг тодотгон шалгах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, бэлэн байдлыг хангах	III/20-ны өдөр	ОБГ	-
1.3	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулийн үед дундын хянагчаар үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг томилох, үүрэг чиглэлээр хангах	III/17	ОБГ	ГХА, МА
1.4	Орон нутгийн хэмжээнд нисдэг тэрэг буух, газар хөдлөлтийн үед иргэд аюулгүй “Цугларах цэг”-ийн тэмдэг тэмдэглэгээнд үзлэг хийж хэвийн байдлыг хангах	III/20	ОБГ	Баян-Өндөр сум
1.5	Газар хөдлөлтийн аюулын болон дадлага сургуулийн үеийн дохио, бичвэр мэдээлэл, зурагт хуудас, аудио хоолой бичлэгийг зарлан мэдээллийн систем, дуут дохиоллын цамхагт суулгах, шалгах	III/25-ны өдрийн дотор	ОБГ	АЗДТГ

Хоёр. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сурталчилгааны талаар

2.1	Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолын хүрээнд зохион байгуулах ажлын талаар хэвлэлийн бага хурал хийж иргэдэд мэдээлэл хүргэх	III/18	ОБГ	-
2.2	“Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа хангах” агуулгын хүрээнд хичээлийн консфект бэлтгэн бие бүрэлдэхүүнд сургалт, мэдээлэл орж үүрэг чиглэл өгөх	III/18	ОБГ	Баян-Өндөр, Жаргалант сум
2.3	Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолын хүрээнд их, дээд сургуулийн оюутнууд, коллеж, ЕБС, цэцэрлэгийн сурагч, хүүхдүүдэд анхан шатны мэдлэг олгох	III/25-ны өдрийн дотор	БГ	ОБГ
2.4	Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах” өдөр болгосны дагуу алба хаагчид хариуцсан байгууллагад газар хөдлөлтийн чиглэлээр сургалт зохион байгуулж сурталчлан таниулах	III/25-ны өдрийн дотор	ОБГ	БГ, Баян-Өндөр, Жаргалант сум
2.5	Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлага сургуулийн бэлтгэл ажлын болон дадлага сургуулийн явцыг цахим мэдээллийн самбараар олон нийтэд сурталчлах	Тогтмол	ОБГ	АЗДТГ
2.6	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр болон Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор иргэд байгууллагын цахим болон фэйсбүүк хуудсанд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг шторк, иргэдэд зориулсан зөвлөмжийг бэлтгэн байршуулж олон нийтэд сурталчлах	Тогтмол	ОБГ	Бүх байгууллага
2.7	“Хүн нэг бүрийн үүргэвч”-ийг бэлтгэхийн ач холбогдлыг тайлбарлан, таниулах ажлыг зохион байгуулах	III/25-ны өдрийн дотор	ОБГ	Баян-Өндөр, Жаргалант сум
2.8	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхтэй оролцох талаар ухуулга хийх	III/25-ны өдрийн дотор	ГХА, МА	ОБГ
2.9	Цахим орчин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах болон гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор иргэд хэрхэн ажиллах тухай сурталчлах	III/25-ны өдрийн дотор	ОБГ	АЗДТГ

2.10	Тусгай тоноглогдсон автомашины чанга яригчаар зарлан мэдээллийн дуут дохиог ажиллуулж сурталчлах	III/25-ны өдрийн дотор	ОБГ	Баян-Өндөр, Жаргалант сум
2.11	Гамшгийн аюул түүнээс хамгаалах, урьдчилан сэргийлэх тухай "Анхаар", "what3words" аппликейшнийг ажилтан бүрийн гар утсанд татаж суулгах ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг хангуулах	III/25-ны өдрийн дотор	ОБГ	Баян-Өндөр, Жаргалант сум
2.12	"Цугларах" талбайд цугларсан иргэдийн бүртгэлийг хялбар аргаар хийх зохион байгуулалтын арга хэмжээг авах	III/26	ОБГ	ГХА, МА
2.13	Зохион байгуулсан арга хэмжээний илтгэх хуудсыг баталгаажуулан Онцгой байдлын газрын Урьдчилан сэргийлэх тасгийн Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэнд ирүүлэх	III/26	ОБГ	-

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 26-ны өдрийн А/383 дугаар
захирамжийн 03 дугаар хавсралт

**ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА, МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БИЕ
БҮРЭЛДЭХҮҮНИЙ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ТУХАЙ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго:

1.1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/383 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг шалгалт явуулах, үнэлэх журам” -ыг хэрэгжүүлэх гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 17:00 цагт аймгийн хэмжээнд зохион байгуулахтай холбогдуулан бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор орон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, бэлтгэл бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөлт, хор уршгийг арилгах талаар зохион байгуулж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааг шалгаж, үнэлгээ, дүгнэлт өгөх, зөрчил дутагдлыг арилгуулахад оршино.

Хоёр. Зохион байгуулалтын талаар:

2.1. Удирдамжид заасан гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах чиглэлийн дагуу хэсэгчлэн Үндэсний аюулгүй байдлын нарийн бичгийн даргын 2011 оны 8 дугаар тушаалын дагуу хүн нэг бүрийн анхан шатны тусламжийн үүргэвчинд байх 15 нэр, төрлийн бүтээгдэхүүн, хэрэгслийг бүрдүүлж, сайн дурын хэсэг, мэргэжлийн ангийг бүрэн хамруулж оролцуулах бөгөөд Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга өөрийн биеэр удирдан зохион байгуулна.

2.2. Ажлын хэсэг үзлэгийн дүнг аймгийн Засаг даргад танилцуулж баталгаажуулна.

2.3. Үзлэгийн үр дүнгийн талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулж ажиллана.

Гурав. Зохион байгуулах хугацаа:

3.1. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 17:00 цагт “АМАРЫН ТАЛБАЙ”-д зохион явуулна.

Дөрөв. Зохион байгуулах бүрэлдэхүүн:

Бэлэн байдлын үзлэгийн удирдагч:	Г.Нэргүйбаатар	Онцгой байдлын газрын орлогч, УСТ-ийн дарга, ГХУХАБайцаагч, хошууч
Штабын дарга	Х.Баатарзориг	Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч
Гишүүн	Н.Норовсүрэн	Захиргаа, цэргийн алба хариуцсан мэргэжилтэн, ахмад

С.Саруул

Бүсийн дүн бүртгэл хариуцсан ахлах
мэргэжилтэн, ахмад

Б.Ганзориг

Сургалт хариуцсан мэргэжилтэн,
ахмад

Тав. Хяналт хариуцлага

5.1.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн хүрээнд тодорхой ажил зохион байгуулаагүй, хариуцлагагүй хандсан, удирдамжид тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн, хууль ёсны шаардлага хүлээж аваагүй, албан тушаалтнуудад холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.

5.2.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн дүнг аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргад танилцуулна.

00